



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**Аудитын ерөнхий дүгнэлт: ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОДИТОЙ
ХИЙГЭЭГҮЙГЭЭС АНХ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХОЁР УДАА ТОДОТГОЛ
ХИЙСЭН БАЙНА.**

Аудитын нэр:

ТӨВ АЙМГИЙН 2013 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Зуунмод
2014 он**

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар.....3
ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....4-5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Аудитын дүн.....
Аудитын менежер О.Амаржаргал	БҮЛЭГ -1
Аудитор Ж.Бямбацогт	Дүгнэлт 1
2014 оны 05 дугаар сарын 16	Аймгийн орон нутгийн орлогын зохих хэсгийг бүрдүүлж буй ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байна.6-8
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://tuv-audit.mn/	БҮЛЭГ- 2
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 22582 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт 1
ХАЯГ:	Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 24 нэр төрлийн орлогоос 20 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.....9-10
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	БҮЛЭГ- 3
	Дүгнэлт 1
	Бараа үйлчилгээний зарим нэр төрлийн урсгал зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.....11-13
	Дүгнэлт.....14
	Зөвлөмж.....15
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....16

Товчилсон үгийн тайлбар

ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
УБ	Улаанбаатар
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЕЗ	Төсвийн ерөнхий захирагч
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗГ	Засгийн газар
БОГ	Байгаль орчны газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төв аймгийн Аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт: Төв аймгийн 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж дүгнэлт гарган ҮАГ-т хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

- 1.Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- 2.Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- 3.Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

Аудитын хамрах хүрээ: Аудитаар орон нутгийн төсөв, Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын сан, ТЕЗ болон орон нутгийн ТЕЗ-чид, төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн хууль
- Хүнийн хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Хүний хөгжил сангийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн: Аудитыг Төв аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, аудитор Ж.Бямбацогт 2014 оны 05-р сарын 12-ноос 05-р сарын 16-ныг хүртэл хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын ерөнхий зүйл, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, хавсралт гэсэн агуулгаар бичигдсэн.

Бүлэг 1

Аймгийн орон нутгийн орлогын зохих хэсгийг бүрдүүлж буй ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байна.

Аймгийн нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөөг татварын бааз суурь, ногдуулалт, урьд оны гүйцэтгэл, ХБГүйцэтгэл, УИХ, Сангийн яамнаас өгсөн чиглэлийг үндэслэн аймаг, сумын ИТХурлын хуралдаанаар хэлэлцүүлэн баталж байна. Төсвийн зарлагын төлөвлөгөөг Засгийн Газрын 2012 оны 30-р тогтоолоор баталсан орон нутгийн төсвийн аргачлалын дагуу тогтмол болон хувьсах зардал, орон нутгийн суурь зардалд хамрагдах халамжийн зардал, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тооцон төсвийн төлөвлөлтийг хийсэн. Аймаг сумын ОНХСангийн төлөвлөлтийг мөн тогтоолоор баталсан аргачлалын дагуу хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, алслалт, татварын идэвхи санаачилга гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан тооцож хуваарилан батлуулж байна. Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсөвт байгууллагуудын төсвийг харьяа салбарын яамдуудад хүргүүлэн хянуулж аймгийн ИТХурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Төв аймгийн 2013 оны төвлөрсөн төсвийн орлогыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 2-р хуралдааны 05 тоот тогтоолоор нийт дүнгээр 60550.5 сая төгрөгөөр баталсан ба 2013 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 6-р хуралдааны 01 тоот тогтоолоор 61768.9 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Үүнд:

- 2013 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 9207.2 сая төгрөг
- Татварын ба татварын бус орлого 9376.7 сая төгрөг
- Орлогын шилжүүлгээр Орон Нутгийн Хөгжлийн санд 7621.6 сая төгрөг
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад олгох санхүүжилтийг 32626.8 сая төгрөг
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого төлөвлөгөөг 46.1 сая төгрөгөөр
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлийг 1531.6 сая төгрөг
- Аймгийн төсвийн хэмнэлтийг 268.9 сая төгрөг
- Хандив тусламж, хөрөнгийн орлогыг 1100.1 сая төгрөгөөр тус тус баталсан

Төв аймгийн 2013 оны нэгдсэн төсвийн нийт 12.9 хувийг татварын орлого, 2.2 хувийг татварын бус орлого, 84.8 хувийг тусламжийн болон хөрөнгийн орлого бүрдүүлж байна.

№	Төсвийн орлого	Баталсан төсөв /сая төгрөг/	Оны дундуур тодотгосон төсөв /сая төгрөг/	Жилийн эцсийн тодотгосон төсөв /сая төгрөг/
1.1	Татварын орлого	8741.7	-135.0	7998.0
1.2	Татварын бус орлого	873.7	+411.0	1368.6
2	Хөрөнгийн орлого	10.0		10.0

3	Тусламжийн орлого		
3.1	Хандив тусламжийн орлого	+750.4	1090.1
3.2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	9102.0	9207.2
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	9000.3	7621.7
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	32776.8	32626.8
3.5	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	+1531.6	1531.6
3.6	Аймгийн төсвийн хэмнэлтийн үлдэгдэл	+268.9	268.9
3.7	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын өөрийн орлого	46.1	46.1
	Нийт дүн	60550.6	2826.9
			61768.9

Аймгийн 2013 оны төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 3 удаа тодотгосон байна. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 02 тоот тогтоолоор аймгийн 2013 оны төсвийн орлого зарлагын төлөвлөгөөг 2826.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон. Үүнд:

- 2013 оны эхний батлагдсан төлөвлөгөөнөөс 611.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцохдоо цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогыг 200.0 сая төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлогын төлөвлөгөөг газрын дуудлага худалдааны анхны үнийн төвлөрөх орлогоор 261.0 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 150.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.
- Автотээврийн хэрэгслийг эзэмшигчийн харьяалалын дагуу УБ серийн дугаартай тээврийн хэрэгслийн татварыг харьяа нийслэл дүүргийн төсөвт төвлөрүүлэх болсонтой холбогдуулан авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 135.0 сая төгрөгөөр, Ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг БОНХЯамны усны дүгнэлт, гэрээг үндэслэн усны төлбөрийг 200.0 сая төгрөгөөр нийт 335.0 сая төгрөгөөр бууруулсан байна. Тухайлбал: Сэргэлэн сумын аж ахуйн нэгжүүдийн ус ашигласны төлбөрийг 2013 оны төлөвлөгөөнд Туул голын сав газраар тооцож төлөвлөсөн байтал усны дүгнэлтээр бусад газрын үнэлгээгээр үнэлэгдснээс 800.0 сая төгрөгөөр, Заамар суманд үйл ажиллагаа явуулж байгаа Алтан дорнод Монгол ХХК, Мондулаан ХХК-уудын ашиглах усыг гадаргын усаар тооцсоныг дүгнэлтээр газрын доорх усаар тооцож ирүүлснээс 847.3 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Мөн сумдын байгаль орчны улсын байцаагч, аж ахуйн нэгжүүдтэй холбогдон авсан судалгаа, сумдын Засаг дарга нарын ирүүлсэн тооцоо судалгааг үндэслэн Борнуур, Жаргалант, Цээл сумдын төлөвлөгөөг нийтдээ 247.3 сая төгрөгөөр бууруулж тооцсон байна.

Төсвийг оны эцэст тодотгосон байгаа нь батлагдсан төлөвлөгөөг мөрдөж ажиллахгүй, тасарсан орлогыг багасгаж, төсөв зарцуулсны дараа гүйцэтгэлд тохируулан тодотголыг баталсан байна. Тухайлбал: төсвийн шилжих үлдэгдэл, хандив тусламжийн орлого гэх мэт.

Аймгийн орон нутгийн орлогын зохих хэсгийг бүрдүүлж буй ус рашаан ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй, ус ашиглах дүгнэлт, ногдуулалт, төлөвлөгөө, гүйцэтгэл ихээхэн зөрүүтэй байна.

Аймгийн Аудитын газраас 2013 онд “Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн

этгээдийн үйл ажиллагаа хууль тогтоомжинд нийцэж байгаа байдал"-д гүйцэтгэлийн аудит хийхэд БОНХЯ-наас гаргасан дүгнэлтээр 22 аж ахуйн нэгжээс 3389.2 сая төгрөг, Туул голын сав газрын дүгнэлтээр 3 аж ахуйн нэгжээс 33.0 сая төгрөгийн усны төлбөр төлөхөөр гарч байжээ.

2013 онд төлөгдөх ус ашигласны төлбөрийг БОНХЯ, Туул голын сав газар, Аймгийн БОГазрын, гаргасан дүгнэлтэнд үндэслэн тооцож үзэхэд төлбөрийг аймаг, орон нутгийн төсөвт илүү төвлөрүүлэх боломжтой байна. Мөн дээрх аудитаар орлогын төлбөрийн ногдуулалтийг хийхдээ өмнөх оны төлсөн мөнгөнд тааруулж хийдэг, өглөг, авлага үүсгэдэггүй, татвар төлөгчтэй холбоотой судалгаа шинжилгээ хийдэггүй, ихэнхи ААНБ-ууд ус ашиглах дүгнэлт гаргуулж гэрээ байгуулаагүй, зөвшөөрөл аваагүй, эрхийн бичиг олгогдоогүй, тоолуур тавиулаагүй, ус ашигласны төлбөрөө төлөөгүй, төлөвлөсөн хэмжээнээс илүү ус ашигласан зэрэг зөрчил илэрсэн байна. Үүнээс үзэхэд усны төлбөрийн төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байна.

Мөн түүнчлэн Татварын ерөнхий газраас оны дундуур автомашины серийн дугаараар авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг, өөрөөр хэлбэл Төв аймгийн иргэний УБ серийн дугаартай автомашины татвар нийслэл, дүүрэгт төвлөрүүлэх шийдвэр гаргасан нь төсвийн төлөвлөлтөнд нөлөөлж байна.

Бүлэг 2

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 24 нэр төрлийн орлогоос 20 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.

Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 6-р хуралдааны 01 тоот тогтоолоор 61768.9 сая төгрөгөөр, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоолоор 1287.3 сая төгрөгөөр баталж, тодотгон баталсан ба гүйцэтгэлээр 63255.0 сая төгрөг төвлөрсөн байна.

- Тайлант онд батлагдсан төлөвлөгөөний дагуу улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 9207.2 сая төгрөгийг авсан.
- Орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор ХХОАТатварын буцаан олголтонд 355.5 сая төгрөгийг хасч нийт 10664.0 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр нийт 11424.8 сая төгрөгийн орлого төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 760.8 сая төгрөгөөр илүү буюу 107.1 хувиар давж биелэсэн.
- Орон Нутгийн Хөгжлийн санд 7621.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 6924.1 сая төгрөг санхүүжигдэж, батлагдсан төлөвлөгөөнөөс 697.5 сая төгрөгийг дутуу санхүүжигдсэн.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 32626.8 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна. Өөрийн орлого төлөвлөгөөгөөр 46.1 сая төгрөг батлагдснаас, гүйцэтгэлээр 153.0 сая төгрөгийн орлого оруулсан байна.
- Аймгийн 90 жилийн ойн баяр наадмын зохион байгуулахтай холбогдуулан хандив тусламжийн орлогыг 1090.1 сая төгрөгөөр тодотгон батлагдсан ба гүйцэтгэлээр 1118.6 сая төгрөгийг төвлөрсөн.

Орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр:

№	Төсвийн орлого	Тодотгосон төлөвлөгөө /сая төгрөг/	Аудитлагдсан гүйцэтгэл /сая төгрөг/
1.1-2	Татварын ба Татварын бус орлого	10664.0	11424.8
3.1	Хандив тусламжийн орлого	1090.1	1118.6
3.2	Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг	9207.2	9207.2
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	7621.7	6924.1
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	32626.8	32626.8
3.5	Аймгийн төсвийн шилжих үлдэгдэл	1531.6	1531.6
3.6	Аймгийн төсвийн хэмнэлтийн үлдэгдэл	268.9	268.9
3.7	Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын өөрийн орлого	46.1	153.0
	Нийт дүн	63056.2	63255.0

Төв аймгийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар аудитлагдсан төсвийн орлогыг 63255.0 сая төгрөгөөр баталгаажуулсан бол

Сангийн яаманд 62174.8 сая төгрөгөөр нэгтгэсэн байна. Сангийн яам ямар үндэслэлээр аудитлагдсан орлогын дүнг өөрчилж нэгтгэсэн нь тодорхойгүй байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр батлагдсан төлөвлөгөөгөөр орон нутгийн болон аймгийн төвлөрсөн төсвийн орлогоор ХХОАТатварын буцаан олголтонд 355.5 сая төгрөгийг хасч нийт 10664.0 сая төгрөг төвлөрүүлэхээс, гүйцэтгэлээр нийт 11424.8 сая төгрөгийн орлого төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 760.8 сая төгрөгөөр илүү буюу 107.1 хувиар татварын болон татварын бус орлого давж биелэсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 24 нэр төрлийн орлогоос 20 нэр төрлийн орлого 101.9-476.9 хувиар биелсэн ба Ус рашааны нөөц ашигласны төлбөр 278.3 сая төгрөгөөр буюу 15.1 хувиар, байгалийн ургамал ашигласны төлбөр 1.9 сая төгрөгөөр буюу 59.2 хувиар, үйл ажиллагааны орлого 132.0 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар нийт 4 нэр төрлийн орлого 15.1-59.2 хувиар тасарсан байна. Үүнд:

1. 2013 оны ноосны урамшууллын орлогоос тооцох орлогын тодорхой хэсэг Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу 2014 онд 50 хувь нь орж ирснээс сумдын төсөвт төвлөрөх жишиг татварын орлого нь тасарсан.
2. 2013 онд ойн сан бүхий сумдууд болох Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад хуш модны самар ургаагүйгээс байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого тасарсан.
3. Заамар, Сэргэлэн сумдад үйл ажиллагаа явуулдаг алт олборлогч компаниуд болох Мон дулаан ХХК, Алтан Дорнод Монгол ХХК-иуд 2013 оны усны төлбөрийн ногдуулсан орлогыг он дамжуулан төвлөрүүлсэнээс усны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан.
4. Өмч хувьчлалын орлогын хувьд аймаг, сумын ИТХ-ын шийдвэртэй худалдах хөрөнгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна.

Бүлэг 3

Бараа үйлчилгээний зарим нэр төрлийн урсгал зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлангаар 2013 онд батлагдсан төлөвлөгөөгөөр 63131.2 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 61820.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 1311.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Сангийн яам Төв аймгийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ ИТХурлаар баталсан төсвийн зардлын төлөвлөгөөг 120.9 сая төгрөгөөр, аудитлагдсан гүйцэтгэлийг 817.6 сая бууруулж нэгтгэсэн байна.

Аудитлагдсан төсвийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулвал: / сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт/-/ хэмнэлт/+
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДІН	63,131.23	61,820.10	1,311.1
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДІН	63,131.23	61,820.10	1,311.1
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДІН	54,051.98	53,263.51	788.5
Бараа, үйлчилгээний зардал	44,746.04	44,899.26	(153.2)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	26,724.84	26,369.57	355.3
Үндсэн цалин	23,443.51	23,318.31	125.2
Нэмэгдэл, урамшил	640.68	567.26	73.4
Гэрээт ажилчдын цалин	1,278.00	1,207.19	70.8
Унаа хоолны хснгөлсөлт	34.28	28.74	5.5
Ір дінгийн урамшуулал	1,328.36	1,248.07	80.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,941.81	2,882.98	58.8
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	15,079.40	15,646.71	(567.3)
Тогтмол зардал	5,412.09	5,210.03	202.1
Гэрэл цахилгаан	502.24	508.88	(6.6)
Тїлш, халаалт	4,800.39	4,594.45	205.9
Цэвэр, бохир ус	109.46	106.70	2.8
Бараа, үйлчилгээний бусад зардал	9,667.31	10,436.69	(769.4)
Бичиг хэрэг	98.25	105.21	(7.0)
Тээвэр (шатахуун)	672.18	739.26	(67.1)
Шуудан холбоо	83.71	82.47	1.2
Дотоод албан томилолт	240.36	241.24	(0.9)
Гадаад томилолт /арга хэмжээ/	30.00	16.53	13.5
Ном хэвлэл авах	43.96	40.94	3.0
Хичээл їйлдвэрлэлийн дадлага хийх	86.61	85.90	0.7
Сургалт, семинарын зардал	22.87	30.02	(7.1)
Эд хогшил худалдан авах	85.28	167.16	(81.9)
Нормын хувцас зєєлєн эдлэл	89.07	89.36	(0.3)
Хоол	2,312.23	2,255.14	57.1
Эм	235.09	233.34	1.7
Урсгал засвар	197.72	320.15	(122.4)
Урлагын уран бїтээлийн зардал	82.00	78.63	3.4
Тєлбєр хураамж болон бусад зардал	156.00	218.64	(62.6)
Гадаад зочны зардал	3.96	3.82	0.1
Биеийн тамирын уралдаан тэмцээн	67.50	66.14	1.4
Аж ахуйн материал худалдан авах зардал	1.69	2.61	(0.9)
Холбооны суваг ашигласны хєлс	5.79	5.87	(0.1)

Байрны тїрээсийн зардал	2.51	1.21	1.3
Тєвлєрсєн арга хэмжээ	56.43	198.55	(142.1)
Урьд оны тєсвийн хэмнэлтийн зарцуулалт	-	293.87	(293.9)
Гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээний зардал	80.53	77.90	2.6
Байгаль орчныг хамгаалах, нєхєн сэргээх арга хэмжээ	1,153.73	886.65	267.1
Соёл урлаг хєгжїлэх зардал	0.01	0.01	-
Хот суурингийн ерєнхий тєлєвлєгєєний зардал	0.05	0.05	-
Газрын зургийн зардал	4.00	5.00	(1.0)
Гудамжны гэрэлтїлэг	70.00	70.00	-
Харуул хамгаалалтын зардал	-	3.93	(3.9)
Ажил їйлчилгээний хєлс	3.00	1.62	1.4
Тєвлєрсєн тєсвийн хуваарилагдаагї зардал	-	7.04	(7.0)
Баяр наадмын зардал	8.18	16.83	(8.7)
Шагнал, тэтгэмжийн зардал	7.28	8.69	(1.4)
Засварын зардал	-	0.02	(0.0)
Маягт хэвлэх зардал	0.38	1.28	(0.9)
ЦАУЗБК-ын зардал	3.00	2.97	0.0
Бусад зардал	276.80	288.14	(11.3)
Бусад нэр тєрлийн хувиарлагдаагї	2,168.65	1,927.19	241.5
Банкны їйлчилгээний хураамж	1.07	1.11	(0.0)
Улсын тооллогын зардал	0.30	0.51	(0.2)
Ногоон хувьсгалын хєтєлбарийн зардал	4.93	4.93	-
INTELSAT ба RETURERS-ийн суваг ашигласны тєлбєр	0.47	0.36	0.1
Хичээл, їйлдвэрлэлийн дадлага, сургуулилт	79.75	76.58	3.2
Сургалт, семинар зохион байгуулах зардал	0.45	0.45	0.0
Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон зардал	231.18	231.25	(0.1)
Мєрийн хєтєлбєрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжїлэх	4.01	4.01	-
Эмнэлгийн ажилтаны мэргэжил дээшлїлэх зардал	0.27	0.18	0.1
Мал эмнэлгийн їйлчилгээний зардал	350.00	341.60	8.4
Сумдад тєрийн захиргааны ажилтан бэлтгэх	38.09	38.09	-
Уран бїтээл хийлгэх, бэлтгїлэх	-	9.00	(9.0)
Тєрийн ємнєєс гїйцэтгїлсэн ажил їйлчилгээ	137.11	176.84	(39.7)
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох їйлчилгээний хєлс (гадаад)	11.25	10.55	0.7
Банк, санхїйгийн байгууллагын їйлчилгээний хураамж	3.25	2.37	0.9
Аудит, зэрэглэл тогтоох їйлчилгээний хєлс (дотоод)	3.41	2.30	1.1
Эд хєрєнгийн даатгал	3.59	2.83	0.8
Тээврийн хэрэгслийн даатгал	8.85	5.58	3.3
Галын даатгал	0.67	0.56	0.1
Харуул, хамгаалалтын хєлс	2.85	2.85	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3.68	2.21	1.5
Мэдээлэл сурталчилгааны зардал	10.70	33.28	(22.6)
Газрын тєлбєр	1.50	-	1.5
Хог хаягдал устгах, цэвэрлэх	50.99	55.72	(4.7)
Бусад зардал	312.19	799.51	(487.3)
Дотоодын эх їїсвэрээс санхїїжилж байгаа	57.96	60.65	(2.7)
Татаас ба урсгал шилжїлэг	9,305.94	8,364.25	941.7
Татаас	-	4.00	(4.0)
Єндєр настны тэтгэвэр	177.76	174.81	2.9
Хєдєлмєрийн чадвар тїр алдсаны тэтгэмж	-	1.58	(1.6)
Жирэмсэн амаржсаны эхийн тэтгэмж	738.02	279.71	458.3
Халамжийн тэтгэвэр	4,024.54	4,051.64	(27.1)
Жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмж	1,140.96	1,067.65	73.3
Халамжийн бусад хєнгєлєлт-їйлчилгээ	0.69	0.69	-
Хїїхдэд олгох мєнгєн тэтгэмж	0.69	0.69	-
Олон нийтийн оролцоонд тїшиглэсэн халамжийн їйлчилгээ	34.34	38.49	(4.1)
Амжиргааг дэмжих нєхцєлт мєнгєн тусламж	412.03	233.83	178.2
Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг	505.20	217.46	287.7
Тэтгэвэрийн нєхєн олговор	22.71	23.47	(0.8)
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	209.16	234.91	(25.8)
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мєнгєн тэтгэмж	819.32	776.46	42.9
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	0.80	-	0.8

Нэг удаагийн буцалтгүй тусламж	29.06	33.32	(4.3)
Шагнал, урамшил	17.76	15.31	2.4
Сонгуулийн йр дйнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	-	8.50	(8.5)
Хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж	431.03	413.34	17.7
Идийн цай	628.85	596.85	32.0
Төлбөр, хураамж	13.04	12.30	0.7
Гадаад шилжүүлэг	100.00	179.27	(79.3)
ХСРӨНГИЙН ЗАРДАЛ	9,079.24	8,556.60	522.6

2013 оны төсвийн гүйцэтгэлийн бүлгийн дүнгээр авч үзэхэд Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардал 355.3 сая төгрөгөөр, НДШимтгэлийн зардал 58.8 сая төгрөгөөр хэмнэлттэй, татаас урсгал шилжүүлэг 941.7 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 522.6 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй, бараа үйлчилгээний урсгал зардлыг 567.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Зардлын зүйлээр авч үзвэл цалин НДШ-ийн зардлын гүйцэтгэл дунджаар 98-98.7 хувь, тогтмол зардал 96.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан бүлэглэлийн журмын дагуу зарцуулагдаж гэрэл цахилгааны зардал хэтрэлттэй, түлш халаалт, цэвэр бохир ус хэмнэлттэй гарч бүлгийн дүнгээрээ хэтрээгүй байна.

Бусад бүлэг доторхи зардлыг зүйлээр авч үзэхэд 48.3-189.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал засварын зардал, эд хогшил худалдан авах зардал төлбөр хураамжийн зардлууд 130-189.3 хувиар хэтэрсэн нь Алтанбулаг, Заамар, Жаргалант, Борнуур, Угтаалцайдам, Баянөнжүүл, Лүн сумдууд эд хогшил худалдан авах зардлыг, Өндөрширээт, Алтанбулаг Батсүмбэр, Зуунмод, Мөнгөнморьт, Угтаалцайдам, Эрдэнэ сумдууд урсгал засварын зардлыг, Баян, Баянчандмань, Эрдэнэ сумдууд төлбөр хураамжийн зардлуудыг хэтрүүлсэн байна. Энэ нь 2012 оны шилжих үлдэгдэл болон давсан орлогыг сумын ИТХурлаар зөвхөн зардлаа тодотгож, эх үүсвэрийн орлогын нэр төрлийг тодорхой зааж батлаагүйгээс аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хэтрэлттэй нэгтгэгдсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2637.7 сая төгрөгийн 14 төрлийн хөрөнгө оруулалт, их засварын ажил батлагдснаас 2130.1 сая төгрөгийн 12 ажил хийгдсэн гүйцэтгэлтэй байна. Баянцогт суманд гаргах худаг, Баянхошууны замын гүйцэтгэл дутуу байна. ЗГ-ын 2013 оны 321-р тогтоолын дагуу 2 ажлын тендерийн 156.2 сая төгрөг буцаан татагдаж, хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Аймгийн ИТХурлын 2012.12.14-ны хуралдаанаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр орлогын шилжүүлэгээр 9000.3 сая төгрөг, зарлагыг сумдын ОНХсанд олгох орлогын шилжүүлэг 5400.1 сая төгрөг аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 3694.2 сая төгрөгөөр батлагдсан байна. Төв аймгийн ИТХурлын 2013.12.03-ны өдрийн хуралдаанаар аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр орлогын шилжүүлэгээр 7621.6 сая төгрөг, хандив тусламжийн орлого 1090.1 сая төгрөг, зарлага сумдын ОНХсанд олгох орлогын шилжүүлэг 4573.1 сая төгрөг аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 4138.6 сая төгрөгөөр тодотгон батлагдсан байна.

ОНХөгжлийн сангийн эх үүсвэр тодотгосноор 7621.6 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, 1090.1 сая төгрөгийн хандив нийт 8711.7 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 7580.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж батлагдсанаас 1131.2 сая төгрөгийн дутуу санхүүжигдсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Аймгийн орон нутгийн орлогын зохих хэсгийг бүрдүүлж буй ус, рашаан ашигласны төлбөрийн төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байна.
2. Орлогын нэр төрлөөр авч үзэхэд 24 нэр төрлийн орлогоос 20 нэр төрлийн орлогын төлөвлөгөө давж биелсэн байна.
3. Бараа үйлчилгээний зарим нэр төрлийн урсгал зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Баярбат, Санхүү Төрийн Сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт нарт зөвлөх нь:

- Орон нутгийн орлого эх үүсвэрийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг хянаж үнэн зөв мэдээлэх
- Санхүүгийн тайлангийн орлого, зарлагыг НББОУСтандарт, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмын дагуу бэлтгэж үнэн зөв тайлагнаж байх
- Татварын орлогыг зөрүүтэй нэгтгэж, тайлагнасан албан тушаалтанд хариуцлага тооцож, хариу мэдэгдэх
- Төсвийн зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41100, Зуунмод, Төв аймаг
Утас: 70273025 Факс: 70272237

2014.05.16 № 05/784
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газраас 2014 онд хийгдэж буй
Төв аймгийн 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцав.

Аудитын тайлангаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг
хүлээн зовшоорч, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА _____ Ю.БЯМБАЦОГТ



02 0725
My doc: ~/2014 on/ AS 1001